



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

С.Р.С. &
Б. Чорбагсай

Завханы газрын
дэргэдүм

дэд. 01.03

179

Танай _____ -ны № _____ Т _____

МЗ-80
Н.Отгонзоров
Завханы газрын
дэргэдүм
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитын тайлан, дүгнэлт,
1304/76/76/А1370614/ЗАА-2024/188/НА-СТА-ТШЗ,
1304/77/77/А1370614/ЗАА-2024/188/НА-СТА-ТШЗ,
дугаартай албан
1305/30/30/А1370614/ЗАА-2024/188/НА-СТА-ТШЗ,
1305/90/90/А1370614/ЗАА-2024/188/НА-СТА-ТШЗ
дугаартай төлбөрийн актыг хүргүүлэв.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР
Д.БАТ-УНДРАА



013030150

01/09/2012



[Faint, illegible handwritten text, possibly bleed-through from the reverse side of the page.]



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

дод4 оны од сарын д3 өдөр

Дугаар Б04/22/22/4137064/344-дод4/183/41-СТ - Т43 улиастай

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Биеийн тамир, спортын улсын хорооноос спортын арга хэмжээ зохион байгуулах зориулалтаар шилжиж ирсэн 70,000.0 мянган төгрөгийг аймгийн 100 жилийн ойн хүлээн авалт болон морины бай шагналын зардалд, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас баяр наадмын үйл ажиллагаанд зориулан, нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн зардлаас "Завхан-100" хүндэтгэлийн арга хэмжээнд оролцох алба хаагчдын унааны зардалд 4,500.0 мянган төгрөг, "Steppe Arena" төрийн бус байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан томилолтын хуудсаар 6,512.0 мянган төгрөгийн албан томилолт олгож, хүндэт зочдын буудлын төлбөрт 5,980.0 мянган төгрөг, хоолны зардалд 13,378.1 мянган төгрөг, гарын бэлэг худалдан авах зардалд 16,360.0 мянган төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан, үндсэн үйл ажиллагааны зардлаас байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын зардалд 8,400.0 мянган төгрөг зарцуулсан нь сургалт хийснийг нотлох тайлан, бусад холбогдох баримтгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй ажлаар явсан, нутгийн зөвлөл, баяр наадмын комисс болон төрийн бус байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан томилолтын хуудсаар 19,199.0 мянган төгрөгийн, албан ёсны дуудсан бичиггүйгээр явсан ажилд 4,544.0 мянган төгрөгийн, дуудсан албан бичгээс 1-4 хоногоор илүү 4,218.0 мянган төгрөгийн томилолтыг тус тус тооцон олгож, албан томилолтын зардлыг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-д "Хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх", 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн



GOVERNMENT OF INDIA
MINISTRY OF DEFENCE
OFFICE OF THE SECRETARY

03/08/2020

хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан”, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл, зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан болон нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулах төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, үрэлгэн зардал гаргахгүй байх,
2. Зарцуулалтын анхан шатны баримтын бүрдлийг хангалттай, зохистой бүрдүүлж хэвших;
3. Албан томилолтыг сургалт, семинарын хугацаатай уялдуулан олгож байх;
4. Цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Мягмарсүрэн, нягтлан бодогч Н.Отгонзаяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

Ц.ОЮУНСУВД





ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

᠒᠐᠒4 оны ᠐᠗ сарын ᠒1 өдөр

Дугаар ᠖᠐5/3030/᠕1370᠖14/᠑᠕᠕-᠒᠐᠒4/188/᠕᠕ СТА-7᠒3
Улиастай

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан хаагчдад 2,364,068 төгрөгийн илүү цагийн нэмэгдлийг илүү тооцож, олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3 дахь хэсгийн 3-д “Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна” гэж заасныг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно”, 4.2.3.3 “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь

1.Дээрх зөрчилд тогтоосон төлбөрийн 2,364,068 (хоёр сая гурван зуун жаран дөрвөн мянга жаран найман) төгрөгийг аймгийн төрийн сангийн бусад нэр заагдаагүй орлогын 100090000955 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Мягмарсүрэн, нягтлан бодогч Н.Отгонзаяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА
Ц.ОЮУНСУВД





ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

᠒᠐᠒4 оны ᠐᠒ сарын ᠒᠖ өдөр

Дугаар 1305/᠑᠐/᠑᠐/᠕37᠐᠖14/34A-᠒᠐᠒4/188/᠕A-CTA-7᠒3
Улиастай

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн 100-н жилийн ойгоор идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан гэх үндэслэлээр байгууллагын албан хаагчдад 9,925,000 төгрөгийн үнэ бүхий зүйл дурсгаж, гарын бэлэг өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/᠑5 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно”, 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь

1. Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчилд тогтоосон төлбөрийн 9,925,000 (есөн сая есөн зуун хорин таван мянга) төгрөгийг аймгийн төрийн сангийн бусад нэр заагдаагүй орлогын 100090000955 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Мягмарсүрэн, нягтлан бодогч Н.Отгонзаяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

Ц.ОЮУНСУВД



AZERBAIJAN REPUBLIC
MINISTRY OF FOREIGN AFFAIRS
BAGDAD

1992-05-15
1992-05-15

1992-05-15
1992-05-15

1. The Ministry of Foreign Affairs of the Republic of Azerbaijan
has the honor to inform you that the Ministry of Foreign Affairs
of the Republic of Azerbaijan has received the letter of the
Ministry of Foreign Affairs of the Republic of Iraq dated
1992-05-15, regarding the issue of the...
2. The Ministry of Foreign Affairs of the Republic of Azerbaijan
has the honor to inform you that the Ministry of Foreign Affairs
of the Republic of Azerbaijan has received the letter of the
Ministry of Foreign Affairs of the Republic of Iraq dated
1992-05-15, regarding the issue of the...
3. The Ministry of Foreign Affairs of the Republic of Azerbaijan
has the honor to inform you that the Ministry of Foreign Affairs
of the Republic of Azerbaijan has received the letter of the
Ministry of Foreign Affairs of the Republic of Iraq dated
1992-05-15, regarding the issue of the...
4. The Ministry of Foreign Affairs of the Republic of Azerbaijan
has the honor to inform you that the Ministry of Foreign Affairs
of the Republic of Azerbaijan has received the letter of the
Ministry of Foreign Affairs of the Republic of Iraq dated
1992-05-15, regarding the issue of the...
5. The Ministry of Foreign Affairs of the Republic of Azerbaijan
has the honor to inform you that the Ministry of Foreign Affairs
of the Republic of Azerbaijan has received the letter of the
Ministry of Foreign Affairs of the Republic of Iraq dated
1992-05-15, regarding the issue of the...
6. The Ministry of Foreign Affairs of the Republic of Azerbaijan
has the honor to inform you that the Ministry of Foreign Affairs
of the Republic of Azerbaijan has received the letter of the
Ministry of Foreign Affairs of the Republic of Iraq dated
1992-05-15, regarding the issue of the...
7. The Ministry of Foreign Affairs of the Republic of Azerbaijan
has the honor to inform you that the Ministry of Foreign Affairs
of the Republic of Azerbaijan has received the letter of the
Ministry of Foreign Affairs of the Republic of Iraq dated
1992-05-15, regarding the issue of the...
8. The Ministry of Foreign Affairs of the Republic of Azerbaijan
has the honor to inform you that the Ministry of Foreign Affairs
of the Republic of Azerbaijan has received the letter of the
Ministry of Foreign Affairs of the Republic of Iraq dated
1992-05-15, regarding the issue of the...
9. The Ministry of Foreign Affairs of the Republic of Azerbaijan
has the honor to inform you that the Ministry of Foreign Affairs
of the Republic of Azerbaijan has received the letter of the
Ministry of Foreign Affairs of the Republic of Iraq dated
1992-05-15, regarding the issue of the...
10. The Ministry of Foreign Affairs of the Republic of Azerbaijan
has the honor to inform you that the Ministry of Foreign Affairs
of the Republic of Azerbaijan has received the letter of the
Ministry of Foreign Affairs of the Republic of Iraq dated
1992-05-15, regarding the issue of the...



1992-05-15
1992-05-15



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 1304/76/76/11370614/3AA-2023/188/НА- Улиастай

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн болон тэтгэвэрт гарсан албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журамд заасан гэх үндэслэлээр 1,400.0 мянган төгрөгийн тэтгэмж, Төрийн одон медалиар шагнуулсан 2 албан хаагчид 400.0 мянган төгрөгийн дагалдах мөнгөн шагнал олгож, аймгийн 100-н жилийн ойн үйл ажиллагаанд 12,483.6 мянган төгрөгийн шатахууныг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй”, 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 1.7-д “Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан”, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл, зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг холбогдох хууль, журамд нийцүүлэн өөрчлөлт оруулах;
2. Батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулж, үрэлгэн зардал гаргахгүй байх;

3. Цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Мягмарсүрэн, нягтлан бодогч Н.Отгонзаяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

АХЛАХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

Ц.ОЮУНСУВД

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэл

Аудитын нэр: Аймгийн ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлангийн аудит
 Байгууллагын нэр: Аймгийн Засаг даргын Тамгын газар

Аудитын код: ЗАА-2024/188/НА-СТА-ТШЗ

№	Аудитын чиглэл/ асуулт	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /төгрөгөөр/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгадагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
1	Аймгийн ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлангийн аудит	Аймгийн ОНХС-аас нэмэлт санхүүжилтийн дансаар дамжсан баар наадмын зардлаас "Завхан-100" хүндэтгэлийн арга хэмжээнд оролцох автобусны зардал 4,500.0 мянган төгрөг гаргаж, "Sterre Arena" төрийн бус байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан томилолтын хуудсаар 6,512.0 мянган төгрөгийн албан томилолт олгосон, хүндэт зочдын буудлын төлбөрт 5,980.0 мянган төгрөг, хоолны үнэ, ус ундаанд 13,378.1 мянган төгрөг, гарын бэлэгний үнэ 16,360.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан.	46,730,100.0	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага өгсөн
2		Аймгийн 100 жилийн ойн арга хэмжээнд төсвөөс 12,483.6 мянган төгрөгийн шатахуун үрэлгэн зарцуулсан.	12,483,579	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага өгсөн
3		Аймгийн 100 жилийн ойн ажлаар УБ хот явсан албан хаагчдад Нутгийн зөвлөл, баар наадмын комисс болон төрийн бус байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан томилолтын хуудсаар албан томилолт олгож, томилолтын зардлыг үрэлгэн зарцуулсан.	16,927,000	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага өгсөн
4		Автомашинд засвар үйлчилгээ хийлгэхээр УБ хот руу явсан албан хаагчдад засварын газраар букуу төрийн бус байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан томилолтын хуудсаар томилолт олгосон. Мөн албан ёсны дуудсан бичиггүйгээр явсан албан хаагчдад 9-14 хоногоор томилолт тооцож олгосон, албан томилолтыг дуудсан бичгээс 1-4 хоногоор илүү тооцож олгосон, мал тооллогын ажлаар суманд ажилласан 3 албан хаагчид томилолтын мөнгө илүү тооцон олгож, томилолтын зардлыг үрэлгэн зарцуулсан.	11,034,000	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага өгсөн

5	Биеийн тамир, спортын улсын хорооноос аймгийн Биеийн тамир спортын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар шилжиж ирсэн 70,000.0 мянган төгрөгийн санхүүжилтээс 40,000.0 мянган төгрөгийг хүлээн авалтын зардалд, 30,000.0 мянган төгрөгийг морины бай шатналд зориулалт бус зарцуулсан. Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй.	70,000,000	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага өгсөн
6	ЗДТГ-ын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын зардалд 8,400.0 мянган төгрөг зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн. Сургалтын үр дүнгийн тайлан байхгүй, зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй.	8,400,000	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага өгсөн
7	Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн болон тэтгэвэрт гарсан 6 албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журамд заасан гэх үндэслэлээр тэтгэмж олгосон.	1,400,000	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага өгсөн
8	Төрийн одон медалиар шагнуулсан 2 албан хаагчид Засгийн газрын тогтоол зөрчиж, дагалдах мөнгөн шагнал олгосон	400,000	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага өгсөн
9	24 албан хаагчид илүү цагийн нэмэгдлийг Засгийн газрын тогтоол зөрчиж, илүү тооцож олгосон.	2,364,067.8	Төлбөрийн акт тогтоох	Хүлээн зөвшөөрсөн	Төлбөрийн акт тогтоос
10	Аймгийн 100 жилийн ойгоор идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан албан хаагчдад үнэ бүхий зүйл дурсгаж, урамшуулсан.	9,925,000	Төлбөрийн акт тогтоох	Хүлээн зөвшөөрсөн	Төлбөрийн акт тогтоос
11	Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор баталсан бүтцэд байхгүй зөвлөхийн орон тоонд 2 ажилтан ажиллуулж, Засгийн газрын тогтоол, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн.	21,800,000	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага өгсөн
Нийт дүн		201,463,746.8			

Бэлтгэсэн:

Ахлах аудитор



Ц.Оюунсүвд

2024.02.23

Хянасан:


Аудитын менежер

Х.Болдбаатар

2024.02.23

Танилцаж зөвшөөрсөн:

Аймгийн ЗДТГ-ын дарга



Г.Мягмарсүрэн

Нагтлан бодогч



Н.Отгонзава



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг

Утас/Факс: 7046-36-12

И-мэйл: zavkhan@audit.gov.mn

дод 4.00.03 № 17д

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Биеийн тамир, спортын улсын хорооноос спортын арга хэмжээ зохион байгуулах зориулалтаар шилжиж ирсэн 70,000.0 мянган төгрөгийг аймгийн 100-н жилийн ойн хүлээн авалт болон морины бай шагналын зардалд, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас баяр наадмын үйл ажиллагаанд зориулан, нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн зардлаас "Завхан-100" хүндэтгэлийн арга хэмжээнд оролцох албан хаагчдын унааны зардалд 4,500.0 мянган төгрөг, "Steppe Arena" төрийн бус байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан томилолтын хуудсаар 6,512.0 мянган төгрөгийн албан томилолт олгосон, хүндэт зочдын буудлын төлбөрт 5,980.0 мянган төгрөг, хоолны зардалд 13,378.1 мянган төгрөг, гарын бэлэг худалдан авах зардалд 16,360.0 мянган төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан, үндсэн үйл ажиллагааны зардлаас байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын зардалд 8,400.0 мянган төгрөг зарцуулсан нь сургалт хийснийг нотлох тайлан, бусад холбогдох баримтгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй ажлаар явсан, нутгийн зөвлөл, баяр наадмын комисс болон төрийн бус байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан томилолтын хуудсаар 19,199.0 мянган төгрөгийн, албан ёсны дуудсан бичиггүйгээр явсан ажилд 4,544.0 мянган төгрөгийн, дуудсан албан бичгээс 1-4 хоногоор илүү 4,218.0 мянган төгрөгийн томилолтыг тус тус тооцон олгож, албан томилолтын зардлыг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-д "Хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх", 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хувлиар зөвшөөрөөгүй бусад"

ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.МЯГМАРСҮРЭН-Д

Нягтлан бодох
Н.Отгон-Завс
Хаммаа В.
Засаг дарга
06.11.23

15 дугаар зүйлийн 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 15.2.3-т “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 39,299.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 64,971.5 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 99,9811.8 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын шийдвэрээр акталж, 8,350.1 мянган төгрөгийн хөрөнгийг төсөвт байгууллагуудад шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар 24 албан хаагчид 2,364.1 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдлийг илүү тооцож олгосон, аймгийн 100-н жилийн ойгоор идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан албан хаагчдад үнэ бүхий зүйл дурсгаж, гарын бэлэг худалдан авах зардалд 9,925.0 мянган төгрөг зарцуулсан, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн болон тэтгэвэрт гарсан албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журамд заасан гэх үндэслэлээр 1,400.0 мянган төгрөгийн тэтгэмж, Төрийн одон медалиар шагнуулсан 2 албан хаагчид 400.0 мянган төгрөгийн дагалдах мөнгөн шагнал олгосон, ойн үйл ажиллагаанд 12,483.6 мянган төгрөгийн шатахууныг үрэлгэн зарцуулсан, аймгийн Засаг даргын зөвлөхийн орон тоонд 2 ажилтан ажиллуулж, 21,800.0 мянган төгрөгийн цалин олгосон зэрэг зөрчил байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгийн бүртгэлд үлдэх өртөггүй 278,784.7 мянган төгрөгийн 191 нэр төрлийн хөрөнгө байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА